

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАР

Завхан аймгийн Дөрвөлжин сумын Буурал, Тавантолгой, Онц багуудын нутаг дэвсгэрт гүн өрмийн иж бүрэн худаг шинээр гаргах ажлыг гүйцэтгэхэд худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2011, худгийн цооногийн хийц, зохиомж, барилгын ажлыг MNS 6088:2010 стандартыг мөрдлөг болгон доорхи нөхцөлийг хангаж ажиллана.

№	Үзүүлэлтүүд	
1. Цооногийг тоноглох		
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: нэг цагт 2м ³ -6м ³ ус өгөх хүчин чадалтай байна.	
1.3	Суултын яндангийн материал нь ган хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 30мм-ээс багагүй залгаасгүй байна.	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй	
1.8	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй	
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх	
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглох	
1.11	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах	
1.12	Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/	
2. Худгийн насос, генератор, цахилгааны утас, хянах самбар		
2.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.	
2.2	Цахилгааны утас: 3-4 салаа, ус чийгний хамгаалалтай, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчиж (туузаар ороож болохгүй) тогтооно.	
2.3	Хянах самбар: Асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан / гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай,	
2.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.	
3. Худгийн барилга		

3.1	Худгийн барилгын дотор багтаамж нь 12м ² –ээс багагүй дотор талдаа усан сан, халаах зуух, цооногоос усан сан, усан сангаас мал услах онгоц руу ус дамжуулах хоолойтой, барилга нь гадна талдаа хаяавчтай байна. Барилгын 3*4 харьцаатай сендвичээр хийх.	
4. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх		
4.1	Худгийн паспортыг бэлтгэх	
4.2	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх	
4.3	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт хийх	

ЗАСАГ ДАРГА  Б.ЧИНБААТАР



Техникийн тодорхойлолт

1. Худгийг иж бүрэн барьж байгуулах /иж бүрдэлд: цооног 159 мм-325мм диаметртэй өрөмдөх, шавхалт туршилтын ажлыг 24 цаг хийх, ус шахуурга, цахилгааны үүсгүүрийг сонгон суурилуулах. Ашиглалтын ундарга нь 2- м³, 10,6л/с-ээс 1,8л/с/ доошгүй байх, цооногийн техникийн паспортыг хөтөлж сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх /хавсралт/

2. Тавантолгой багийн Дааган дэл, Буурал багийн 2 Ташрын дунд, Онц багийн Шиврээ гэх уст цэгийн хайгуултай цэгт худгуудыг гаргана.

3. Худгийн цооногийн хийц зохиомжийг MNS:6088-2010 стандартын шаардлагад нийцүүлэн, өрөмдлөгийн ажлын дараахь шавхалтын ажлын үр дүнгээр худгийн ундарга 0,6л/с-ээс бага бол цоног ашиглах боломжгүй гэж үзэх ба тухайн гидрогеологийн нөхцөлд усны динамик түвшин нь хамгийн бага гүнд байхад шаардлагатай ундаргыг хангасан байхаар тооцож, цооног өрөмдөх, худгийн цооногийн шүүрийн цувааны диаметр нь түүний дотуур ус шахуургыг саадгүй суулгах, дахин сугалах боломжтой байх, чанарын хувьд шаардлага хангасан ашиглах боломжтой уст үеийг бусад шаардлагаа хангахгүй уст үеэс сайтар зааглаж хаасан байх, худгийн цооногийн чулуулгийн уст үе, бусад үе давхаргын элс шавар гэх мэт сэвсгэр болон үйрмэг чулуу нурж унахгүй нөхцөлийг хангахаар бодож суултын яндангаар сайтар хааж бэхлэх, шаардлагатай тохиолдолд шүүрийн цувааны доод амсарыг битүүлж таглах, цооногийн хийц зохиомж нь түүнийг ашиглах ба сэргээн засварлахад төвөгтэй биш байвал зохино. Өрөмдлөгийн нийт гүн 120-140м-ээс дээш байна.

4. Өрөмдлөгийн ажлын журнал хөтөлнө. Энэ журналд өрөмдлөгийн ажлын талаархи тодорхой мэдээллийг тусгах.

Өрөмдлөгийн ажлын үед өрөмдлөг болон шүүрийн яндангийн диаметрын зөрүү 50мм-ээс багагүй байхыг, шүүрийн яндан ус шахуургын диаметрын зөрүү 50мм-ээс багагүй байхыг, шүүрийн яндан суулгалгүй үндсэн чулуун ханатай цооногийн диаметр ус шахуургын диаметрын зөрүү 50м-ээс багагүй байхыг тус тус техникийн хувьд хориглоно. Өрөмдлөгийн ажил дууссаны дараа шавхалтын ажлыг хийж гүйцэтгэх ба шавхалтын журналыг дэлгэрэнгүй үйлдэх,

5. Усны хийцийн болон бактериологийн шинжилгээг хийлгэж үр дүнг хавсаргах.

6. Уст цэгийн геоцахилгаан зүсэлтийг Хавсралт-ын дагуу бэлтгэх. Усгүй буюу хэт бага устай гэж тодорхойлогдсон газар өрөмдөж илүү зардал гаргахгүй байхад анхаарах.

7. Худгийн хүчин чадалд тохируулан шинэ ус шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгон суурилуулах ажлуудыг гүйцэтгэнэ. Ус шахуурга, цахилгаан үүсгүүр нь барааны Олон улсын ISO-9001 стандарттай байх. Барааны гарал, үүслийн тодорхойлолт, тухайн компаний бараа үйлдвэрлэх эрхийн бичиг, нийлүүлэх барааны техникийн үзүүлэлтийг нотолсон үйлдвэрлэгч компаний хэвлэмэл танилцуулга, ашиглалтын заавар, ашиглалтын зааврыг монгол хэл дээр бэлтгэсэн болно.

8. Шинээр гаргаж буй худгийн цооногийг гаргаж, худгийн гүн, ундарга, статик, динамик түвшин зэргийг бүрэн тодорхойлсны дараа насосыг сонгон авч угсрах нь зүйтэй.

9. Худгийн моторын яндан заавал худгийн барилгаас гадагш гаргах эсвэл цонхтой байх, худгийн хаалгыг салхи уруу харуулах, худагт цонх гаргах.

10. Худаг орчмын малчдын бүлэг, багийн засаг дарга нарыг байлцуулан худаг хүлээн авах комисст хүлээлцэх, худгийн эзэмшил ашиглалтын талаар заавар өгч, эзэмшигчийг тодруулсан тухай хурлын тэмдэглэл авч ирүүлэх.

**Завхан аймгийн Дөрвөлжин сумын орон нутгийн
хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд шинээр
гаргах гүн өрмийн худгийн захиалга**

№	Багийн нэр	Эзэмших малчин	Гүний хэмжээ /метр/	Уст цэгийн хайгуултай эсэх	худгийн тоо	Худаг гаргуулах газрын нэр	Байршил /тодорхой бичих/	Усан хангамжийн хэрэгцээ		Хэрэгцээ шаардлага
								өрхийн тоо	Малын Тоо /хонин толгой/	
1	Буурал баг	Эзэмших малчинг багийн хурлаар шийдвэрлэх	180	+	1	2 Таширын дунд	Сумаас баруун хойш 35 км	25	26000	Хүн малын ундны ус хүрэлцэхгүй байна
2	Таван толгой		140	+	1	Дааган дэл	Сумаас баруун тийш 140 км	30	25000	
3	Онц		70	+	1	Шиврээ	Сумаас баруун тийш 235 км	10	9500	
Нийт дүн					3					